



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/4/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2020 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn Ахлах аудитор: О.Нарангарав Утас: 70523020 Цахим хаяг: Narangarav.o@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө	8
2.8.2 Авлага.....	8
2.8.3 Урьдчилгаа	9
2.8.4 Бараа материал	9
2.8.5 Үндсэн хөрөнгө	10
2.8.6 Өр төлбөр.....	10
2.8.7 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	13
2.11. Шилэн дансны мэдээлэл	13
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3. Менежментийн захидал.....	15
3.1 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой асуудал.....	15
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	17
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	19
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	21
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	24
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	26
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан

1. Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020-03-25 № 1-Е/369

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.ОДБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01002 161

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Сайншанд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын ТТЗ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч С.Одбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 17-оос 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/257 дугаар бүхий албан бичгээр 2020 оны 03 дугаар сарын 06-ний өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дорноговь аймгийн Санхүү төрийн сангаас боловсруулан гаргасан санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн

Сайншанд сумын ТТЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019 онд харьяа орон нутаг дахь төсөвт байгууллага, сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сайншанд сумын ТТЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэл санхүүгийн тайлангийн нийт зардлын сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 9,818.4 сая төгрөгийн 1 хувь буюу 98.2 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 219.5 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үед материаллаг байдлыг 2019 оны хагас жилийн тайлангийн дүнгээр сонгон авсан тул өөрчлөн жилийн эцсийн тайлангаар материаллаг байдлыг тодорхойлсонтой холбоотой.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 28 төсвийн байгууллага, 4 тусгайн сан, төсөвт байгууллагын 15 ахмадын сан, нийт 47 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 28 төсвийн байгууллага 2 тусгай сан аудитад хамрагдсан байна. Төсвийн шууд захирагчийн 24 байгууллагад санал дүгнэлт өгөхөөр, тусгай сангийн 2, ТШЗ-ийн 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд дараах дүгнэлтүүдийг өгсөн байна.

- “Зөрчилгүй” дүгнэлтийг 21 байгууллагад
- “Хязгаарлалттай” дүгнэлтийг 3 байгууллагад – Ерөнхий боловсролын 1, 4 дүгээр сургуулиуд, Зүүнбаян багийн 7 дугаар цэцэрлэг

Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 137.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 84.0 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 53.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг менежментийн захидлаар хүргүүлээ.

Сайншанд сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,531.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 572.0 сая төгрөгийн 15 алдааг аудитын явцад залруулж, 2.4 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 525.3 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 2,432.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 41 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Сайншанд Тохижилтын газрын 2,100.3 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 475.5 сая төгрөгийн, Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 301.8 сая төгрөгийн, зөрчил нь Сайншанд сумын ТТЗ-ийн нэгтгэл тайлангийн тоон үзүүлэлтээр тооцсон материаллаг байдалд нөлөөлж байгаа боловч уг зөрчлийг аудитын явцад залруулан бүртгэх боломжтой НББ-ийн алдаа байсан тул шинж чанарын хувьд материаллаг байдалд нөлөөлөхгүй гэж үзсэн болно.

Харин Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд илэрсэн 53.0 сая төгрөг, Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 20.8 сая төгрөг, нийт 73.8 зөрчил нь Сайншанд сумын ТТЗ-ийн нэгтгэл тайланд тооцсон материаллаг байдлаас бага байгаа тул дүгнэлтэд нөлөөлөхгүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн, данс буруу хөтөлсөн зэрэг 84.0 сая төгрөгийн залруулга хийлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд авлагаар тоосон 32.9 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, 12.8 сая төгрөгийн зардлыг буруу дансанд бүртгэсэн,
- Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдлүүдийг зөрүүтэй илэрхийлсэн 38.3 сая төгрөгийн алдааг залруулав.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 572.0 сая төгрөгийн 15 залруулга хийлээ. Тухайлбал:

- **СХС-ийн санхүүгийн тайланд:** Тайлант онд олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгийн тооцооллыг санхүүгийн тайлантай тулгаж үзэхэд 5.0 сая төгрөгийн хүү, алданги болон авлагын үлдэгдлийг зөрүүтэй тооцсон 2 алдааг залруулан бүртгэв.
- **ОНХС-ийн санхүүгийн тайланд:** Тайлант онд хэрэгжиж дууссан ажлын гүйцэтгэлийн зардлыг дутуу тооцон авлага, өр төлбөрийг дутуу бүртгэсэн, санхүүжилт, зардлын гүйцэтгэлийг дутуу бүртгэсэн зэрэг 229.1 сая төгрөгийн 4 алдааг залруулан бүртгэв.
- **Сумын Засаг даргын тамгын газрын тайланд:** холбогдох тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд хаасан, данс буруу бүртгэсэн зэрэг 32.5 сая төгрөгийн алдааг залруулан бүртгэсэн байна.
- **Сумын Зүүнбаян багийн ЗАА-ын тайланд:** данс буруу бүртгэсэн, хөрөнгийн элэгдэл тооцоогүй зэрэг 4.9 сая төгрөгийн алдааг залруулан бүртгэсэн байна.
- **Ерөнхий боловсролын сургуулийн тайланд:** Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг бусад орлогоор бүртгэсэн, тооцооны дансаар дамжуулалгүй зардалд шууд бүртгэсэн, үндсэн хөрөнгийн ангилал буруу хийсэн болон үндсэн хөрөнгөнд бараа материалыг бүртгэсэн зэрэг нийт 263.0 сая төгрөгийн алдааг залруулан бүртгэсэн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлтийн хэлбэр, акт, албан шаардлага, зөвлөмжийн зөрчлийг нэгтгэн хавсралт 1, хавсралт 2-оор тус тус үзүүлсэн болно.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 142.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 271.9 сая төгрөг болж, 129.4 сая төгрөгөөр буюу 90.8 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	142.50	271.90	129.40	90.81
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
Дүн	142.50	271.90	129.40	90.81

Эх сурвалж: Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байгаа 271.9 сая төгрөгийн 52.6 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 0.6 сая төгрөг нь ОНХС-ийн дансанд, 92.7 сая төгрөг нь СХС-ийн дансанд, 1.6 сая төгрөг нь байгаль орчны нөхөн сэргээх сангийн дансанд, 122.1 сая төгрөг нь 15 ТШЗ-ийн ахмадын сангийн дансанд, Өрхийн эрүүл мэндийн төвийн 2.3 сая төгрөг нь арилжааны банкны дансанд тус тус байршиж байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,249.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,227.6 сая төгрөг болж, 21.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	6.5	10.1	3.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-

Татаас, санхүүжилтийн авлага	1.0	-	(1.0)
Зээлийн хүүгийн авлага	24.8	16.5	(8.3)
Бусад авлага	252.0	242.5	(9.5)
Зээлийн авлага	965.0	958.5	(6.5)
Дүн	1,249.30	1,227.60	(21.70)

Эх сурвалж: Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдлийн 975.0 сая төгрөг нь СХС-ийн зээлийн авлага, 203.9 сая төгрөг нь ОНХС-ийн дутуу санхүүжилтийн авлага, 48.7 сая төгрөг нь ТШЗ-ийн ажилчидтай болон бусад зардалтай холбоотой авлага байна.

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 51.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 27.7 сая төгрөг болж, 23.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгааны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	44.6	20.8	-23.8
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6.9	6.9	0
Цалингийн урьдчилгаа			0
Томилолтын урьдчилгаа			0
Дүн	51.5	27.7	-23.8

Эх сурвалж: Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд төлсөн 44.6 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрөөч бүртгэн, 20.8 сая төгрөгийн худалдан авалтын шилжүүлгийг урьдчилгаа зардлаар бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын Зүүнбаян багийн 4 дүгээр сургууль нь 2019 онд гэрээний үүргийн хэрэгжилтгүй байхад төсвөөс шилжүүлсэн 20.8 сая төгрөгийг зардлаар бүртгэснийг аудитын явцад залруулан, албан шаардлага өгсөн байна.

2.8.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 1,489.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,783.8 сая төгрөг болж, 294.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	296.20	378.30	82.10
Эм боох материал	10.90	25.80	14.90
Бэлэн бүтээгдэхүүн	1.00	1.00	-
Бичиг хэргийн материал	42.60	42.50	(0.10)
Аж ахуйн материал	744.50	824.30	79.80
Барилгын засварын материал	2.50	7.10	4.60
Сэлбэг хэрэгсэл	28.80	29.20	0.40
Түлш шатах тослох материал	16.70	32.90	16.20
Хүнсний материал	42.80	59.90	17.10
Бусад хангамжийн материал	298.10	376.60	78.50
Мал амьтад	4.90	6.20	1.30
Дүн	1,489.00	1,783.80	294.80

Эх сурвалж: Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд харьяа төсөвт байгууллагууд 1,827.5 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, УТХО болон ОНТХО, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 471.8 сая төгрөг, данс хооронд болон балансаас шилжүүлэн авсан 64.7 сая төгрөг нийт 2,364.0 сая төгрөгийн бараа материал тус тус нэмэгдэж, 2,005.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан, балансаас шилжүүлсэн болон актлан устгасан 64.0 сая төгрөг нийт 2,069.2 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлээс хассан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулагдсан материал байгаа бөгөөд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

2.8.5 Үндсэн хөрөнгө

Цэвэр үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 37,048.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 41,048.4 сая төгрөг болж, 4,000.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №.5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	34,015.44	37,974.97	3,959.53
Барилга, байгууламж, орон сууц	24,219.29	28,702.07	4,482.79
Хуримтлагдсан элэгдэл	(131.29)	(1,279.19)	(1,147.90)
Авто-тээврийн хэрэгсэл	1,363.78	1,704.30	340.52
Хуримтлагдсан элэгдэл	(982.66)	(1,156.44)	(173.78)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,554.87	2,731.14	176.27
Хуримтлагдсан элэгдэл	(1,803.04)	(1,944.32)	(141.27)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,446.96	1,671.54	224.58
Хуримтлагдсан элэгдэл	(765.65)	(862.95)	(97.29)
Зам, гүүрийн байгууламж	2,572.84	2,703.68	130.84
Хуримтлагдсан элэгдэл	(50.70)	(323.64)	(272.94)
Бусад үндсэн хөрөнгө	7,622.86	8,871.05	
Хуримтлагдсан элэгдэл	(2,385.69)	(3,102.86)	
Дуусаагүй барилга, байгууламж	167.27	-	(167.27)
Ном	186.63	260.58	73.95
Биет бус хөрөнгө	3,032.57	3,073.41	40.83
Програм хангамж	33.95	34.66	0.71
Хуримтлагдсан элэгдэл	(25.16)	(31.76)	(6.60)
Бусад биет бус хөрөнгө	3,024.74	3,071.46	46.72
Хуримтлагдсан элэгдэл	(0.95)	(0.95)	-
Дүн	37,048.01	41,048.37	4,000.36

Эх сурвалж: Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд харьяа төсөвт байгууллагууд 507.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэж, УТХО болон ОНТХО, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 6,265.0 сая төгрөг, данс хооронд болон балансаас балансад шилжүүлэн авсан 563.7 сая төгрөг нийт 7,336.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус нэмэгдэж, холбогдох тушаал шийдвэрийн дагуу 295.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан, 24.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хорогдол, 459.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн данс бүртгэлээс хассан байна.

2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 94.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 224.8 сая төгрөг болж, 130.8 сая төгрөгөөр буюу 139.1 хувиар буурсан байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	94.04	224.85	130.81	139.10
Ажиллагсадтай холбогдсон өглөг	3.90	6.70	2.80	71.79
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1.00	8.90	7.90	
Байгууллагат төлөх өглөг	89.10	209.20	120.10	134.79
Хувь хүмүүст төлөх өглөг	0.04	0.05	0.01	25.00
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-	-
				-
Нийт дүн	94.04	224.85	130.81	139.10

Эх сурвалж: Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өглөгийн дансны үлдэгдлийн 203.9 сая төгрөг нь ОНХС-ийн өглөг, 1.5 сая төгрөг нь Нөхөн сэргээх сангийн дансны өглөг, 19.4 сая төгрөг ТШЗ-ийн байгууллагатай холбоотой өр төлбөр байна.

2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Цэвэр хөрөнгө өмчийн дансны эхний үлдэгдэл 39,886.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 44,134.6 сая төгрөг болж, 4,248.4 сая төгрөгөөр буюу 10.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /ЗГ сан/ орон нутгийн сан	15,318.69	15,318.69	-	-
Өмч:Төрийн өмч	15,318.69	15,318.69	-	-
Хуримтлагдсан үр дүн	9,096.74	13,413.80	4,317.06	47.46
Өмнөх үеийн үр дүн	13,138.78	9,162.15	(3,976.63)	(30.27)
Тайлант үеийн үр дүн	(4,042.04)	4,251.66	8,293.70	(205.19)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,470.74	15,402.06	(68.69)	(0.44)
Дүн	39,886.17	44,134.55	4,248.37	10.65

Эх сурвалж: Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд харьяа 13 төсөвт байгууллагад нийт 13.3 сая төгрөгийн НББ-ын бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдсэн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2018 оны 23 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх сумын татварын болон татварын бус орлогыг 1,525.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 1,715.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 12.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл -	Зөрүү /дутуу -, илүү + /	Хувь
Үйл ажиллагааны орлогын татвар	130.00	285.49	155.49	119.6
ҮХХ борлуулсны орлого	95.00	26.02	(68.98)	72.6

Бусад орлогын татвар/Хувь хүнээс суутгасан ОАТ	370.00	456.60	86.60	23.4
Хадгаламж хүү	420.00	598.06	178.06	42.4
Бууны татвар	5.40	5.04	(0.36)	6.7
УТХураамж	155.00	203.95	48.95	31.6
Хог хаягдлын хураамж	176.04	119.93	(56.11)	31.9
ТТАМАТөлбөр	170.21	16.09	(154.12)	90.5
Хүү, торгууль/	4.00	4.25	0.25	6.3
Татварын болон татварын бус орлогын дүн	1,525.65	1,715.43	189.78	12.4

Сумын татварын болон татварын бус орлого 189.8 сая төгрөгөөр давж биелэхэд:

- Үйл ажиллагааны орлогын татвар 155.5 сая төгрөгөөр давсан нь Иргэний үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогыг 100061300911 дансанд төвлөрсөнтэй холбоотой. Татварын хэлтсийн программд өөрчлөлт орсонтой холбоотой ҮХХ борлуулсны орлогын татварыг уг дансанд хаасан

- Хүүгийн орлогын татвар 178.1 сая төгрөгөөр давсан нь иргэдийн хадгаламж өссөн

- Улсын тэмдэгтийн хураамж болон хүү торгуулийн орлого 6.3 сая төгрөгөөр тус тус давсан нь зөрчил гаргасан жолоочийн тоо их байсан, зарим нэг төлөвлөөгүй орлого орсон нь шалтгаалсан.

- Хог хаягдлын хураамж 56.1 сая төгрөг, бууны татвар болон ТТАМАТ 154.5 сая төгрөгөөр тус тус тасалдсан нь ТТАМАТ-ийг хэт өндөр төлөвлөсөн, гэрээг өндөр дүнгээр хийсэн, газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн ажлыг хийсэн аж ахуйн нэгж байгууллагууд УБТЗ-аас санхүүжилтээ дутуу авсан, хог хаягдлын хураамжийн тасралт нь төлөвлөгөө үндэслэлгүй батлагдсан, айл өрхүүд хураамжаа дутуу төлсөн, буутай иргэд буугаа хоорондоо зарсан, эцсийн эзэмшигч нь олдохгүй маргаантай бууны татварыг дутуу төвлөрсөн зэрэг нь тус тус нөлөөлсөн байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 16,215.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 15,792.9 сая төгрөгийг урсгал зардалд, 422.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 4,683.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,732.7 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 50.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдэл санхүүжилтээс, 481.3 сая төгрөгийг ОНХС-ийн санхүүжилтээс, 267.6 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 09/08 дугаар тогтоолоор суманд олгох татаас санхүүжилтийг 1,060.2 сая төгрөгөөр баталсныг 2019 оны 11/09 дүгээр тогтоолоор 53.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,113.3 сая төгрөг болгон төсвийн зохицуулалт хийсэн байна.

Гүйцэтгэлээр 4,683.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 10,732.7 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 74.1 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 421.4 сая төгрөгийг ОНХС-ийн санхүүжилтээс, нийт 15,911.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын 263.6 сая төгрөг нь батлагдсан төсвөөс 9.7 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны орлого 3.1 сая төгрөгөөр давж, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 17.9 сая тасарсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 15,860.7 сая төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь урсгал зардлын зардлын гүйцэтгэл 15,497.0 сая төгрөг буюу 295.8 сая төгрөгийн хэмнэлттэй, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 363.7 сая төгрөг буюу 86.1 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулсан нь шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг авч үзвэл: Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардлын гүйцэтгэл 10,344.3 сая төгрөг, бараа ажил үйлчилгээний зардлын гүйцэтгэл 4,874.2 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 278.5 сая төгрөгийг зарцуулсан нь шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын 19 төсөл, арга хэмжээнд 422.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 362.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, төлөвлөсөн төсөл арга хэмжээнд 363.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Жилийн эцэст сумын татварын болон татварын бус орлогын 179.8 сая төгрөгийн давсан орлого, урсгал зардлын хэмнэлт 217.8 сая төгрөг, нийт 397.6 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Харьяа байгууллагуудын нэмэлт дансанд 2019 онд Засаг даргын хөрөнгөөс олгосон 2.4 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчаас олгосон 226.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын хүрээнд 284.2 сая төгрөг, нийт 512.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нийт санхүүжилтийн зарцуулах эрхийг зохих журмын дагуу аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээр нээлгэн холбогдох бараа үйлчилгээний зардалд 463.4 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 6.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 42.6 сая төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5, 4.6-д харуулав.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Сайншанд сумын ТТЗ-ийн харьяа тусгай шилжүүлгийн байгууллагын батлагдсан төсөвт АИХТ-ын 2019 оны 11/09, 12/07 дугаар тогтоолуудаар тайлант онд нийт 1,383.2 сая төгрөгийн төсвийн тодотгол хийгдсэнийг сумын ИТХ-аар хэлэлцэн батлуулаагүй байна.

Дараагийн аудитаар аймгийн ИТХ-аар баталсан төсөвт нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд сумын ИТХ-аар хэлэлцүүлсэн эсэхийг нягтлан шалгах нь зүйтэй

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд сумын ТТЗ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 120 мэдээллийг хугацаанд нь, 34 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд сумын ТТЗ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Сайншанд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа орон нутгийн төсөвт байгууллагуудын батлагдсан төсөвт аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 11/09 дүгээр тогтоолоор 53,057.5 мянган төгрөгийн нэмэлт өөрчлөлт, төсвийн зохицуулалт хийж төсөвт тодотгол хийгдсэн байхад сумын ИТХ-аар төсвийн тодотголыг батлуулалгүй төсвийн санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6-д "Төсвийн тогтвортой байдлыг хангахад Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулахаар бол доор дурдсан зохицуулалт хийнэ", 64 дүгээр зүйлийн 64.1.2-д " Сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх бүрэн эрхтэй", 66 дугаар зүйлийн 66.1.1-д "Сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл: Төсвийн тогтвортой байдлыг хангагдахгүй байх, төсөв буруу хуваарилагдах, үр ашиггүй зарцуулагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн батлагдсан төсөв, харьяа байгууллагуудын төсөвт хийгдэж байгаа төсвийн нэмэлт өөрчлөлт, төсвийн тодотголыг сумын ИТХ-аар батлуулан түүний дагуу төсвийг хуваарилах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,932,212.91	3,311,048.82
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	142,478.93	271,921.22
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	142,478.93	271,921.22
31210	Төгрөг	142,478.93	271,921.22
31211	Төрийн сангийн харилцах	140,541.73	269,597.13
31213	Арилжааны банк дахь харилцах	1,937.19	2,324.08
33	АВЛАГА	1,249,221.87	1,227,550.78
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6,486.01	10,052.94
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,000.00	0.00
33400	Зээлийн хүүгийн авлага	24,758.34	16,543.96
33500	Бусад авлага	252,013.17	242,488.22
33510	Байгууллагаас авах авлага	247,579.26	240,318.22
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,433.92	2,170.00
33600	Зээлийн авлага	964,964.35	958,465.66
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	964,964.35	958,465.66
33612	Хувь хүмүүст олгосон зээл	964,964.35	958,465.66
34	УРЬДЧИЛГАА	51,470.55	27,740.45
34600	Урьдчилж гарсан зардал	44,550.55	20,820.45
34710	Урьдчилгаа тооцоо	6,920.00	6,920.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6,920.00	6,920.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,489,041.56	1,783,836.38
35100	Түүхий эд материал	307,092.70	404,064.90
35110	Тусгай зориулалттай материал	296,218.59	378,257.44
35130	Эм боох материал	10,874.11	25,807.45
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,000.00	1,000.00
35400	Хангамжийн материал	1,175,983.87	1,372,531.49
35410	Бичиг хэргийн материал	42,648.19	42,534.66
35420	Аж ахуйн материал	744,501.63	824,299.72
35430	Сэлбэг хэрэгсэл	28,761.62	29,173.73
35440	Түлш, шатах тослох материал	16,672.90	32,924.06
35450	Барилгын засварын материал	2,501.81	7,083.03
35460	Хүнсний материал	42,839.48	59,930.00
35470	Бусад хангамжийн материал	298,058.25	376,586.28
35600	Мал амьтад	4,965.00	6,240.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	37,048,010.28	41,048,372.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	37,048,010.28	41,048,372.47
39200	Биет хөрөнгө	34,015,436.80	37,974,967.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	24,219,286.91	28,702,073.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-131,286.71	-1,279,188.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,363,778.05	1,704,298.05
39204	Хуримтлагдсан элэгдэл	-982,664.95	-1,156,443.81
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,554,865.17	2,731,135.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,803,044.42	-1,944,317.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,446,961.76	1,671,541.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-765,654.88	-862,945.66
39209	Зам, гүүрийн байгууламж	2,572,841.44	2,703,680.18
39210	Хуримтлагдсан элэгдэл	-50,704.02	-323,639.54
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,622,855.76	8,871,050.46
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,385,692.38	-3,102,856.02
39216	Дуусаагүй барилга, байгууламж	167,268.36	0.00
39217	Ном	186,626.71	260,579.46
39300	Биет бус хөрөнгө	3,032,573.48	3,073,405.31

39301	Програм хангамж	33,948.05	34,663.05
39302	Хуримтлагдсан элэгдэл	-25,160.56	-31,763.74
39303	Бусад биет бус хөрөнгө	3,024,736.00	3,071,456.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-950.00	-950.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	39,980,223.19	44,359,421.29
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	94,048.96	224,873.09
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	94,048.96	224,873.09
41300	Өглөг	94,048.96	224,873.09
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,879.93	6,743.04
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	986.01	8,903.63
41360	Бусад өглөг	89,183.02	209,226.42
41361	Байгууллагад төлөх өглөг	89,142.99	209,173.95
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	40.03	52.47
